

**“Бугат” элс хайрганы ордын 2024 оны Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

---

**ГАРЧИГ**

Д.д		Хуудасны дугаар
1	Ордын ерөнхий мэдээлэл	2
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	6
3	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	13
4	Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд	18
5	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	21
6	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	25
7	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	25
8	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	25
9	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	25
10	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	27
11	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	28
12	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт	31
13	Дүгнэлт	34

**“Бугат” элс хайрганы ордын 2024 оны Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

---

**1. Газарзүйн байршил**

“Боржгоны тал” ХХК нь Төв аймгийн Алтанбулаг сум болон УБ хотын ХУД-ийн 13 хороо нутагт орших “Бугат” элс хайрганы ордод 2010 оноос эхлэн олборлолт явуулаж байна.

**Орын тусгай зөвшөөрөлтэй талбайн булангийн эргэлтийн  
цэгүүдийн солбицол**

(Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-011875)

Хүснэгт №1

Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	106	36	5.3	47	44	47.77
2	106	36	5.3	47	45	6.78
3	106	35	41.3	47	45	6.78
4	106	35	41.3	47	45	3.95
5	106	35	46.23	47	44	59.02
6	106	35	41.3	47	44	56.37
7	106	35	41.3	47	44	47.77

### Ордын байршлын зураг



#### **Техникийн хүчин чадал**

2024 онд олборлолтын үйл ажиллагаанд дор дурдсан тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй ажилласан.

D-1 Хүрдэт шигшүүр ком 2

D-1 Хүрдэт угаадаг төхөөрөмж ком 2

PYD-900 Конусан бутлуур ком 1

PEW-860 Хацарт бутлуур ком 1

#### **Техник хэрэгсэл**

ZL-50 дугуйт 3м3 шанагтай 3ш утгуурт ачигч

HYUNDAI 290LC-7 маркийн 1,2м3 шанагтай уруу утгуурт экскаватор 1ш

Хово маркийн 20м3-ын автосамосвал 1ш тус тус ажилласан.

Элс, хайрга олборлолтын ажлыг урвуу утгуурт гидравлик экскаватор болон автосамосвалын хослолоор ухаж ачин тээвэрлэн бутлан ангилах хэсгийн хүлээн авах бункерийн дэргэд орших элс хайрганы овоолгод хүргэдэг.

Ил уурхайгаас олборлосон элс, хайргыг бутлан ангилах цехэд ангилаад бэлэн бүтээгдэхүүнийг газар дээрээс нь Улаанбаатар хот болон ойролцоох төв суурин газруудад байрлах бетон зуурмагын үйлдвэрүүдэд нийлүүлдэг бөгөөд тэдгээр бетон зуурмагийн үйлдвэрүүд нь өөрсдийн авто тээврээр газар дээрээс ирж авдаг.

**“Бугат” элс хайрганы ордын 2024 оны Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

---

Тус орд нь ойролцоох төв суурин газруудтай ердийн орон нутгийн чанартай шороон замаар холбогдсон.

**Автотээврийн аюулгүй ажиллагаа**

Ил уурхай дахь зам тээврийн ажиллагаа нь хялбар бус хөдөлгөөний нөхцөлд явагддаг. Ийм учраас аюул осолгүй ажиллахын тулд дараах шаардлагуудыг хангана.

- Замын хөдөлгөөний дүрэм, ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм ба тухайн уурхайд мөрддөг авто аж ахуйн холбогдолтой дүрэм журмыг хатуу баримтлах
- Ил уурхайн авто тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний маршрутын дагуу замыг тэмдэгжүүлэх, гэрэлтүүлэх
- Замын эгзэгтэй хэсгүүдэд хаалт, хамгаалалтын байгууламжуудыг байгуулах
- Замын тойруу хэсгүүдэд хурд хязгаарлах тэмдэгүүдийг байрлуулах
- Ачаалах ба ачаа буулгах үеийн сэлгээний схемүүд, дохиоллын системийг нарийн баримтлах
- Замын эвдрэлийг тухайн бүрт нь засч хэвийн нөхцөл бүрдүүлэх
- Хөдөлгөөнд оролцож буй хүнд даацын машинуудын хооронд зөвшөөрөгдөх зайн хэмжээг замын хэсэг бүрээр тогтоож, хатуу мөрдөх
- Зам тээврийн эрүүл ахуйн нөхцөлийг хангах
- Автотээврийн хэрэгслийн үзлэг, үйлчилгээ, засварыг графикийн дагуу хийж техникийн бүрэн байдлыг хангах ба тохиолдлын чанартай эвдрэл ослоос сэргийлэх
- Ил уурхайн түр замуудад байнга үзлэг хийж хөдөлгөөний аюулгүйн нөхцөлийг хангах зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллах юм.

**Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд**

Одоогийн байдлаар төслийн техник эдийн засгийн үндэслэлд төслийн улмаас хүрээлэн буй орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийн боломжийн хэмжээнд урьдчилан тооцоолж, аль болох бага хэмжээнд байлгах, урьдчилан сэргийлэхийн тулд дараах зүйлсийг тусгалаа. Үүнд:

- Орд нь хөрс хуулалт харьцангуй багатай ордод хамаарах тул хөрсний овоолгод харьцангуй бага талбай шаардагдах бөгөөд төслийн шийдэлд ашиглалтын жилүүд дэх уулын ажлыг хэд хэдэн хувилбараар нарийвчлан төлөвлөсөн.

**“Бугат” элс хайрганы ордын 2024 оны Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

---

- Уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг хийхдээ гадаад овоолгод дарагдах талбайг боломжит хамгийн бага байлгах зорилгод тулгуурлсан бөгөөд ашиглалтын жилүүдэд ашигласан талбай, овоолгуудыг хэлбэржүүлэн техникийн нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж эхэлнэ.
- Ашиглалтын явцад зөвхөн технологийн процессуудад зайлшгүй шаардлагатай замуудыг байгуулан, чиглэлийг тогтоож, тоног төхөөрөмжүүдийг парклах талбайг тусгайлан байгуулж, онц шаардлагагүй зам гаргаж газрын гадарга эвдлэгдэхээс чанд сэргийлнэ.

Хог хаягдлын хяналт, удирдлага, зохион байгуулалтын хувьд энэ үйл ажиллагааг оновчтой шийдэх зорилгоор тусгайлан журам боловсруулж мөрдүүлнэ. Уг зорилтын хүрээнд байгаль орчин болон хог хаягдлын талаархи хууль, тогтоомж, дүрэм, журмуудын дагуу олон улсын стандартын шаардлагаад нийцсэн арга технологийг хэрэгжүүлнэ.

Урьдчилан төлөвлөж байгаагаар ордыг ашиглахад хатуу хог, хаягдал гарахгүй гэж тооцож байгаа ба ажиллагсадаас үүдэлтэй хог хаягдлыг нэгдсэн журмаар зайлуулна. Тоног төхөөрөмжийн эвдэрсэн эд ангиудыг цаашид ашиглахгүй тохиолдолд тусгайлан бэлтгэсэн талбайд цуглуулж, дараа нь уурхайн ашиглагдсан орон зайд булаах боломжтой гэж үзэж байна.

Химийн хорт бодисын хувьд ордыг ашиглахад химийн хорт бодис ашиглахгүй тул энэ төрлийн хог хаягдал гарахгүй.

**Байгаль орчин менежментийн төлөвлөгөөний гол зорилго**

2024 оны байгаль орчин менежментийн төлөвлөгөөний биелэлтийн ажлын гол зорилго нь “Бугат” элс хайрганы ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон цаашид учруулаж болзошгүй сөрөг нөлөөлөлийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ;
2. Орчны тохижилт, нөхөн сэргээлт;
3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ
4. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ

5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ;
6. Химийн бодисын эрсдлийн менежмент
7. Осол, эрсдэлийн менежмент;
8. Хог хаягдлын менежмент;
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр;
10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохионбайгуулалт
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах

## **2. 2024 онд хийсэн нөхөн сэргээлтийн ажил**


### **2.1. Биологийн нөхөн сэргээлт**

Биологийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа нь техникийн үе шат бүрэн дуусаж, овоолгын болон талбайн хөрс чулуулаг тогтворжиж, нягтарсны дараа овоолгод хадгалж байсан шимт хөрсийг эргүүлэн байршуулах замаар биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийдэг.

Тэр бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламжыг нэмэгдүүлэх үүднээс байгаль орчны нарийвчилсан үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаснаар уурхайн тосгоны хажууд үхрийн нүд 50ш, монос 40ш, шар хуайс 2500ш нийт 2610 ширхэг модыг 0,3 га талбайд тарьсан. Мод тарих ажиллах хүч, усалгаанд 5900.0 мян.төг нийт зарцуулсан.



. **БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗУРАГ**



**БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗУРАГ**





**БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗУРАГ**






**БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗУРАГ**







БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗУРАГ





### **3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл**

Элс хайрга олборлох төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд дурдсанаар газрын хэвлийг эвдэж өнгөн хөрс хуулах, карьер нээх, овоолго хийх, олборлох, тээвэрлэх, буталж ангилан ялгаж үйл ажиллагаагаар байгаль дэлхий эвдэрч бохирдохоос гадна тоос гэх мэт агаарт дэгдэх, шатах, материал болон шингэн хаягдал хөрсөнд нэвчих замаар бохирдол үүсч эко системд их бага болон болзошгүй сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Бохирдлын эх үүсвэр нь шороон авто зам, түлш шатахуун агуулах, бохирын цэг, хатуу хог хаягдал, ахуйн химийн бодис зэрэг болно.

Элс хайрганы ордын мөргөцөг дотор элс хайрга олборлож тээвэрлэх үед техникийн буруу үйл ажиллагаанаас болж сөрөг нөлөөллүүд үүсч бий болдог. Үүнд уурхайн мөргөцөг дотор элс хайрга олборлож тээврийн хэрэгсэлд ачих үед хуурай шороо хийсч агаар орчныг бохирдуулж хүний эрүүл мэндэд сөрөгөөр нөлөөлж болзошгүй юм. Үүнийг бууруулахын тулд 2023 онд дараах арга хэмжээнүүдийг авч ажилласан болно.

Үүнд

- 1.. Эксковатор болон ачигч мөргөцөг дотор элс хайрга олборлож байгаа /хуурайшилтын/ үед услаж талбайг чийгшүүлэх замаар тоосжилтын хэмжээг бууруулах арга хэмжээ авч ажилласан.
2. Бульдозер болон ачигчаар уурхай хүртэлх замыг өдөрт нэг удаа хусч замын дэд хэсгийн хуурай сул шороог цэвэрлэж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр үүсэх тоосжилтийг бууруулж ажилласан.
3. Олон салаа зам гаргуулахгүй байх арга хэмжээ авч уурхайгаас Тэрэлж явах төв зам хүртэл сайжруулсан шороон замыг тавьсан.
4. Хүнд машин механизм болон тээврийн хэрэгслүүдийн яндангаас гарах хорт хий / $CO_2$ ,  $NO_2$ ,  $SO_2$ / стандартын хэмжээнд байгаа эсэхийг жилд нэг удаа техникийн үзлэгт бүрэн хамруулж шаардлага хангаагүй техникийг ажиллуулахгүй байх арга хэмжээ авч ажиллаж байна.

#### **3.1 Хог хаягдлын нөлөөлөллийг бууруулах арга хэмжээ**

Ахуйн хаягдал болон үйлдвэрээс гарах бохир усыг хяналтгүй хаясны улмаас орчны хөрс, газрын доорхи ус, ургамалжилтанд дам нөлөөлдөг тул, аль болох бага хог хаягдал үүсгэх, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах замаар

**“Бугат” элс хайрганы ордын 2024 оны Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

---

гарсан хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах, үлдсэн хог хаягдлыг байгаль орчинд аюулгүй арга технологиор устгах зарчмыг баримтлан “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлж байна

**3.2 Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

Элс хайрга олборлолтын үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, тээвэрлэлт, ил задгай хөрснөөс хийссэн тоос нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болдог тул хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд агаарт дэгдэх тоосны хэмжээ харьцангуй ихсэдэг учир хуурайшилт ихтэй улиралд зам талбайг тогтмол худгийн усаар усан зөвхөн зөвшөөрөгдсөн замаар тээвэрлэлт явуулдаг.

Усалгаа хийж буй явцыг зурагт үзүүлэв .





Уурхайд ашиглагдаж буй хүнд машин механизмаас ялгарах утаа хий нь агаарын бохирдлын эх үүсвэр болдог тул техникийн үзлэгт оруулсан, ялгаруулж буй хорт утаа нь стандартын түвшинд буй машин техникийг ашиглах, ашиглагдаж буй машин техникт үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийх, яндан бүрт шүүлтүүр суурилуулж өгөх, тохиргоо техникийн горимыг сайтар мөрдөх, түлшний найрлага, чанар, стандартыг сайтар хянах, чанартай түлш хэрэглэх зэрэг арга хэмжээ авч ажилласан.

### **3.3 Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

Үржил шимт хөрсийг хуулан овоолго үүсгэн технологийн дагуу хадгалж, нөхөн сэргээлтэнд эргүүлэн ашиглаж эргэлтэнд оруулж байна. Хөрсний элэгдэл, эвдрэлийг нэмэгдүүлэхгүйн тулд зөвхөн зөвшөөрөгдсөн замаар тээвэрлэлт явуулна. Шатах, тослох материалыг хөрсөнд нэвчихээс сэргийлж, тэгшилсэн бетонон талбай болон гражид машин техникийн үйлчилгээг хийдэг.

Хүрээлэн буй орчны хөрсний чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.




**“Бугат” элс хайрганы ордын 2024 оны Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

**Хүснэгт 2**

<b>№</b>	<b>Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд</b>	<b>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>	<b>Хамрах хүрээ</b>	<b>Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжиж байгаа, Төлөвлөж байгаа/</b>	<b>Хэрэгжилт</b>
1	Тээвэрлэлтийн замын дагуу олон салаа зам бий болох	Тээвэрлэлтийг зориулалтын замын дагуу явахад хяналт тавих	Уурхайгаас тосгон хүртэл	Тогтмол хэрэгжиж байгаа.	Уурхайн орчин болон бусад үйл ажиллагаа явагдаж буй газарт хяналт тавьж ажиллаж байна. 2024 онд зөрчилгүй ажилласан.
2	Засвар үйлчилгээний явцад асгаралт гарч хөрс бохирдох	Техникүүдэд хяналт тавих, асгаралтаас сэргийлэх, зориулалтын талбайд засвар үйлчилгээг хийлгэх, хяналт тавих	Техникүүдэд	Тогтмол хэрэгжиж байгаа.	2024 онд асгаралт гаргасан зөрчил байхгүй. Зориулалтын засварын газарт үйлчилгээгээ хийлгэж байна.

**Шатах, тослох материалын үйлчилгээ хийдэг зориулалтын  
бэлтгэгдсэн талбай**





Шатах, тослох материалын үйлчилгээ хийдэг зориулалтын  
бэлтгэгдсэн талбай



### **3.4 Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

Усны цогц бодлогын дагуу орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлж, усны хэрэглээг хамгийн бага түвшинд байлгах зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд усны эх үүсвэрүүдэд эрүүл ахуйн болон хамгааллын бүс тогтоож, холбогдох дэглэмийг мөрдөн ажиллаж байна. Усыг тоос дарах зорилгоор ашигладаг. Хог хаягдал, бохир усыг зөвшөөрөгдсөн талбай нүхэнд хийж, шатах тослох материалын асгаралтгүй, хөрсний бохирдолгүй ажилласан нь гүний усанд нөлөөлөх нөлөөлөлгүй болно.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ : Төсөвт өртөг **2000.0** мян.төг болсон.

### **4. 2024 оны байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

Хүснэгт №3

№	Хийгдэх ажлууд	Зардал, мян.төг	тайлбар
1	Ахуйн шингэн хаягдлыг тусгайлан доторлосон нүхэнд хуримтлуулан битүүмжлэх, ариутгал, устгал хийх	500.0	Бүгд биелсэн Ариутгал 2 удаа хийгдсэн
2	Хөрсийг ямар нэг химийн бодисоор бохирдуулах, шатах тослох материалыг ил задгай асгахыг хориглох		Энэ ажил хэвшсэн
3	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг эмх цэгцтэй төвлөрүүлэх нэг цэг байгуулах	1000	Энэ ажил хийгдэж хэвшсэн
4	Машин техникийн үйлчилгээ, засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	-	Энэ ажил хийгдэж хэвшсэн
5	Төв зам болон орд хүрэх зам дагуу, ордын талбай, үйлдвэр орчимд замыг тэмдэгжүүлэх	1000	Энэ ажил хийгдсэн
6	Гал түймэр гарахаас сэргийлэх арга хэмжээг авч, түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл,булан цэгүүд бэлтгэсэн байх.		-
7	Элс хайрга олборлох, тээвэрлэх ажлыг геологи, уул техникийн нөхцөл, зураг төслийн дагуу хийх	-	Уулын ажлын төлөвлөгөөний дагуу хийсэн
8	Уурхай орчмын замын тоосыг усалгаа хийж бууруулах	2500	Төлөвлөгөөний дагуу хийдэг
	дүн	5000.0	Бүгд биелсэн

Ордын талбай, үйлдвэр орчимд замыг тэмдэгжүүлсэн байдал









## **5 .Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

**5.1.** Энэхүү ажлын хүрээнд ХУД-ийн 13- хорооны Шувуун фабрикын айлуудын үерийн улмаас эвдэрч машин, хүн явахад хүндрэлтэй болсон гудамжуудад элс хайрга буулган, дүүргэж тэгшилж өгсөн.

Ажлын хөлсний зардлын задаргаа

Айлын хашааны хажууд овоорсон талбайг тэгшилж янзалсан. 3 өдөр 2 ковштой ажилласан.

Бохир шороо 12 машин  $20\text{м}^3 = 240\text{м}^3$  нэгж үнэ 20.0мян.төг = 4800.0 мян.төг

Ковш 3 өдөр  $360\text{л} * 2770 = 997.2$ мян.төг

Ковш 2өдөр  $240\text{л} * 2770 = 664.8$ иян.төг

Тээврийн хөлс 12 машин  $20\text{м}^3 = 240 * 10000 = 2400.0$ мян.төг

Бүгд зардал 8862,0мян.төг

**5.2.** УБ хотын ХУД-ийн Шувуун фабрикын 60жилийн ойд зориулж 3800.0мян.төгрөгөөр мотоцикл худалдан авч өгсөн.




**5.3** Төв аймагт зуданд нэрвэгдсэн малын сэг зэмийг цэвэрлэх ажилд зориулж 2000.0 мян.төгрөгийн тусламж өгсөн

**Нийт зардал 14660.0 мян.төг**

**“Бугат” элс хайрганы ордын 2024 оны Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**


---

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зураг






**Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зураг**





Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зураг



## **6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

“Бугат” элс хайрган ил уурхайн аргаар ашиглах төсөл-ийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн МУ-011875 дугаартай талбай болон түүний нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэлт хийх айл өрх байхгүй.8

## **7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

Газар шорооны ажлын үед өмнө нь судалж тогтоож чадаагүй археологийн болон түүх соёлын үлдэц, үнэт зүйлс өртөж болзошгүй. Иймд “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн 27.8-д хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргасан.

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах МУ-ын хууль эрх зүйн орчныг дагаж мөрдөх
- Түүхийн болоод соёлын өв сангийн зүйлүүд олдох буюу магадлал ихтэй бол нэн даруй төслийн үйл ажиллагааг зогсоож, орон нутгийн засаг захиргаа мөн улс төрийн болон холбогдох шинэчлэх ухааны судалгааны байгууллагуудад мэдэгдэх
- Түүх, соёлын дурсгал болон ард түмний зан үйлд харшлах зүйлийг хөндөхгүй байхын үүднээс талбайд орших дурсгалт зүйлст хамгаалалт хийх, ойр орчмоор нь машин техник явуулахгүй байхаар зохион байгуулна.

## **8. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт**

“Бугат” элс хайрганы ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөлийн талбайд өрөмдлөг тэсэлгээний ажлыг гүйцэтгэхгүй. Химийн бодис ашиглахгүй

## **9.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт**

. Үйлдвэрийн объект бүрт хог хаягдлыг ангилан ялгаж хаях зориулалтын хогийн сав ба хатуу хог хаягдлыг түр байршуулах цэг байгуулан хамгаалалтын хашаагаар хашсан байна. Үүгээр үйлдвэрийн талбайд хатуу хог хаягдалгүй, хог хаягдал тархалтыг бүрэн хязгаарласан, эмх цэгцтэй байх нөхцлийг бүрдүүлж чадна. Хатуу хог хаягдалыг зөвхөн сумын захиргаанаас зөвшөөрсөн хогийн цэгт тээвэрлэн зайлуулсан.

*Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

*Хүснэгт №4*

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлсэн хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Ахуйн	Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж зориулалтын цэгт хүргэх	Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Улиралд 1 удаа	10,0	2	200,0	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль
Үйлдвэрийн	Үйлдвэрлэлийн гаралтай хаягдлыг ил задгай хаяхгүй зориулалтын битүү саванд ангилан ялгах түүхий эд боловсруулах цэгт нийлүүлэх арга хэмжээнүүдийг авах	Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Улиралд 1 удаа	100,0	2	200,0	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль
Аюултай	Аюултай хог хаягдлыг кодлон ялгаж бүртгэлжүүлэх, стандартын дагуу байгуулсан агуулахад хадгалах, 2 дахь түүхий эд авдаг үйлдвэрт нийлүүлэх	Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Улиралд 1 удаа	75,0	4	200,0	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль  Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
<b>Нэг жилийн зардал</b>						<b>600,0</b>		

“Бугат элс хайрганы ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл”-ийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн зардал **600.0** мян.төг болж зарцуулсан.



## **10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт**

Байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээхэд ордыг ашиглах төслийн ТЭЗҮ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, нөхөн сэргээх төсөл, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу ажилласан.

- Уурхайн хүчин чадал бага тул удирдлагын нүсэр бүтэц байх шаардлагагүй юм. Иймд байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг компаний захирал уурхайн дарга, инженерүүд хариуцан гүйцэтгэх бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар ажиллав.
- Компаний удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль журмын дагуу уурхайн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ.

Удирдлага зохион байгуулалтын зардал

Хүснэгт №5

№	Хийгдэх ажлууд	Зардал, мян.төг	тайлбар
1	Байгаль орчныг хамгаалах, ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалтыг өөрийн ажиллагсдын дунд зохион байгуулах.	2600.0	биелсэн
2	Уурхайн ажилчид мөн ачигчидыг тусгай амны хошуувчаар хангасан.	3000.0	Зардал гараагүй
3	Ой, хээрийн түймрээс сэргийлэх, унтраах хэрэгслээр бүрэн хангах, ажиллагсдыг түймэр унтраах арга барилд сургах, гал түймэр гарсан тохиолдолд шуурхай унтраах арга хэмжээ авах. Байгаль хамгаалагчдад туслах.	-	Зардал гараагүй
	дүн	5600.0	

**“Бугат” элс хайрганы ордын 2024 оны Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

**11.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт**

*Хүснэгт №6*

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжиж байгаа, Төлөвлөж байгаа/	Хэрэгжилт
1	Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	“Боржгоны тал” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Цаг агаарын мэдээг 7 хоног бүр гарган нийт ажилчдад танилцуулан, арга хэмжээг авч ажилласан.
2	Гал түймрийн улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчидад тогтмол хугацаанд танилцуулах	“Боржгоны тал” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Хийгээгүй
3		Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	“Боржгоны тал” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн.	Шаардлагатай цэгүүдэд галын хор, санамж бичиг галын сарааг байршуулсан.
4	Газар хөдлөлт, чичирхийллийн улмаас	Болзошгүй ослын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчидад тогтмол хугацаанд танилцуулах	“Боржгоны тал” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Ажил эхлэхийн өмнө нийт ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажиллаж байна. АА-ны зөрчилгүй ажилласан.
6		Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	“Боржгоны тал” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Нийт ажилчдад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг хуваарилан өгч, шаардлагатай нэг бүрийг хэрэгслийг өгч ажилласан.
7	үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	“Боржгоны тал” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Тогтмол хяналт тавьж ажилласан. 2024 онд гаргасан зөрчилгүй.







## **12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт**

Төслийг хэрэгжүүлсэн явцад байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тухайн орчинд зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, холбогдон гарах зарим зардлуудын хамт тодорхойлж ирсэн.

Төслийг хэрэгжүүлэхэд баримтлан ажиллах ОХШХ нь тус төсөл хэрэгжих орчны байгалийн болон нийгэм эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичгийн нэг юм.

Төслийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явцад хяналт шинжилгээний ажлыг энд тусгасан хугацаа болон аргачлалын дагуу үргэлжлүүлэн хийх нь тухайн төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг шуурхай тогтоохоос гадна түүний олон жилийн судалгааны мэдээ материал нь нутгийн хөрс, ургамал, гадаргын ба газрын доорх ус зэрэг экосистемийн бүрдэл хэсгүүдийн хоорондын харилцан шүтэлцээг тодорхойлж, тэдгээрийн талаарх шинжлэх ухааны мэдлэгийг бий болгох чухал хэрэглэгдэхүүн болно.

Жил бүр хийгдсэн хяналт, шинжилгээний үзүүлэлтүүдийг анхааралтай судалж үзэж байх нь цаашдаа байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчин болон тухайн нутагт оршин суугчдыг төслийн нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг илүү үндэслэлтэй болгох юм. Нөгөө талаас ОХШХ-г улам боловсронгуй болгох хяналт, шинжилгээ хийж байгаа объектоо бүрэн хамарч байгаа эсэхийг хянахад чухал ач холбогдолтой байх болно.

Агаарын тоосжилт харьцангуй багассан. Агаар, ус, хөрсний шинжилгээг БОХЗТЛабораторид хийлгэсэн.



**“Бугат” элс хайрганы ордын 2024 оны Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

Ундны ус , хөрсний шинжилгээг лабораторид хийлгэсэн дүгнэлт

Хүснэгт №7

Хяналт	А.	Б.	В.	Г.
шинжилгээний дээж	Дээж авах цэгийн тоо	Дээж авах цэгийн байршил	Давтамж	Төсөв /мян.төг/
Хөрс	1	Карьер орчимд,	Жилд 1 удаа	100.0
Ундны усанд	2		Жилд 1 удаа	200.0
Нийт				<b>300.0</b>

Усны шинжилгээг лабораторид хийлгэсэн дүгнэлт



**MNAS**  
Accreditation  
system  
ТЭМ  
MNS ISO/IEC

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: bohzt1@gmail.com

**СОРИЛТЫН ДҮН**



**БАЙГАЛЬ**  
Орчин Ажирхайн Төв Лаборатори

Дугаар он/№	: 2024/ Ц-188
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: "Боржгоны тал" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал	: Б.Делгөөн, БОХЗТЛ
Сорьцын тоо, төрөл	: 1, ус
Сорьц авсан огноо	: 2024.08.16
Сорьцын тодорхойлолт	: Хэрэглээний худгийн ус
Шинжилгээний аргын стандарт	MNS ISO 10523:2001, MNS ISO 7888:1999 MNS 1097:2023, MNS 4424:2005 MNS 6832:2020
Шинжилсэн огноо	: 2024.08.19-2024.08.28
Хуудасны тоо	: 2 /2
Үр дүн	: 1

Сорьц авсан цэг	pH	ЕС мкСи/см	SO <sub>4</sub> мг/л	Cl мг/л	Ca мг/л	Mg мг/л	Na+K мг/л	HCO <sub>3</sub> мг/л	Эрд мг/л	Хат мг-экв/л
ХУД, 13-р хороо Бөхөнтүрэн	6.95	659	136	37.0	77.8	10.9	20.2	257.5	539	4.78
MNS 0900:2018	6.5-8.5	1000	500	350	100	30	-	-	-	7.0

Тайлбар: ЕС – цахилгаан дамжуулах чанар, Хат-Хатуулаг, Эрд-Эрдэжилт

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч:

Шалгасан шинжээч:



А.Цолмонбаяр

Ц.Мийдүв

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хүчинтэй.

**“Бугат” элс хайрганы ордын 2024 оны Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

**Хөрсний шинжилгээг лабораторид хийлгэсэн дүгнэлт**



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот  
Утас: 11-341818 И-мэйл: bohzt@gmail.com



**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/№ : 2024/01-402  
 Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Боржгоны тал” ХХК  
 Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Дөлгөөн агаарын хэсэг  
 Сорьцын тоо, төрөл : 2 хөрөнгий сорьц  
 Сорьц авсан огноо : 2024.08.16  
 Сорьцын тодорхойлолт : Улаанбаатар-ХУД 20-р хороо Бөхөн түргэн  
 Шинжилгээний аргын стандарт : SAS A01:2022  
 Шинжилсэн огноо : 2024.08.17  
 Хуудасны тоо : 1/1

№	Сорьц авсан цэгийн нэр	Кадмийн (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Стронци (Sr)
мг/кг								
1	Карьер	0.6	11	<0.005	<0.05	22	28	412
2	Кемп	1.4	15	<0.005	<0.05	<0.05	25	579
MNS 5850:2019/ ЗДХ/		3	100	2	150	300	100	800

Шинжилгээ гүйцэтгэсэн: 


Хянаж баталгаажуулсан: 



Ахлах шинжээч Б.Даваасүрэн


Ахлах шинжээч Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: bohzt@gmail.com




**СОРИЛТЫН ДҮН**


Дугаар он/№ : 2024/ Ц-188  
 Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Боржгоны тал” ХХК  
 Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Б.Дөлгөөн, БОХЗТЛ  
 Сорьцын тоо, төрөл : 1, ус  
 Сорьц авсан огноо : 2024.08.16  
 Сорьцын тодорхойлолт : Хэрэглээний худгийн ус  
 Шинжилгээний аргын стандарт : MNS 6836:2020, MNS 6833:2020  
 MNS 1097:2023, MNS 6779:2019  
 MNS 6834:2020, MNS ISO 6878:2001  
 MNS 4430:2005, MNS 6272: 2011  
 Шинжилсэн огноо : 2024.08.19-2024.08.28  
 Хуудасны тоо : 1 /2  
 Үр дүн : 1

Сорьц авсан цэг	Ж/Б мг/л	ПИЧ мг/л	NH <sub>4</sub> мг/л	NO <sub>2</sub> мг/л	NO <sub>3</sub> мг/л	PO <sub>4</sub> мг/л	Fe мг/л	F мг/л
ХУД, 13-р хороо Бөхөнтүргэн	5.8	0.9	0.02	0.003	18.78	0.011	0.02	0.30
MNS 0900:2018	-	-	1.5	1.0	50	3.5	0.3	0.7-1.5

Тайлбар: Ж/Б-Жингэдэгч бодис, ПИЧ Перманганатын Исэлдэх Чанар

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч: 

Шалгасан шинжээч:



А.Цолмонбаяр

Ц.Мийдүв

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

**“Бугат” элс хайрганы ордын 2024 оны Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

---

**13. ДҮГНЭЛТ**

Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний тухайн жилийн төсөв, биелэлтийг Хүснэгт №6-д үзүүлэв.

Хүснэгт №8

д/д	Мэдээллийн төрөл	мян. төг биелэлт	тайлбар
1	Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	<b>34060.0</b>	
2	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	600.0	
3	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	2000.0	
4	Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв / биологи/	5900.0	
5	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	14660.0	
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	-	Зардал гаргаагүй
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	5600.0	
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	300.0	
9	Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	-	хамааралгүй
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төсөв	5000.0	



**“Бугат” элс хайрганы ордын 2024 оны Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

2

**ТӨВ АЙМАГ БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗАР УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ  
Дугаар 24/85**

2024.09.04

Зуунмод

**1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар**

“Боржгоны тал” ХХК, Ш.Адъяацэрэн, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, УБД:9011043108, РД:2778378, Цахим хаяг: borjgony\_tal@yahoo.com

**2. Төслийн нэр, байршил:** “Боржгоны тал” элс хайрганы орд MV-011875 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, Төв аймаг, Алтанбулаг сумын нутагт байрлалтай.

**3. Төсөл хэрэгжүүлэгч:** “Боржгоны тал” ХХК

**4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат: /X, Y/**

№	X	Y	Талбай
1.	106° 35' 41.3"	47° 44' 47.77"	28.12 га
2.	106° 35' 41.3"	47° 44' 56.37"	
3.	106° 35' 46.29"	47° 44' 59.02"	
4.	106° 35' 41.3"	47° 45' 03.95"	
5.	106° 35' 41.3"	47° 45' 06.78"	
6.	106° 36' 5.3"	47° 45' 6.78"	
7.	106° 36' 5.3"	47° 44' 47.77"	
MV-011875			

**5. Төслийн зорилго:** Уурхайгаас олборлосон элс, хайрганы холимогийг буталж, шигшиж угааж 0-5мм, 5-10мм, 10-20мм байдлаар ялган борлуулна.

**6. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт:** Ашигт малтмал олборлох, баяжуулах, дайрга бэлтгэх бутлуурын үйлдвэр

**7. Төслийн техник, технологиг ажиллах горим, хүчин чадал:** Уурхайд шууд углуурт ачигч Экскаватор Hyundai 3000 LC 1.3 м3, Утгуурт ачигч XCMG ZL-50G 3.0 м3, Бульдозер Shantui-SD23 1.25 м3, Усны машин Цистерн 27 тн тус бүр 1ашиглана.

**8. Жилийн бүтээгдэхүүний хэмжээ:** Хайрга, дайрганы уурхай нь 2024 онд технологийн хэрэгцээнд ус ашиглахгүй, унд ахуй, мод бутны усалгаа болон зам талбайн тоосжилт дарахад ус ашиглана.

**9. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/**

ТЭЗҮ -нд 85%-ийг эргэлтийн усаар, 15%-ийг цэвэр усаар хангахаар тусгагдсан байна. Эргэлтийн усан санг доош нь шингээхгүйгээр цементэлсэн.

Ахуйн хэрэглээний усан хангамжийн өөрийн эзэмшлийн 2023 онд гаргасан гүний худагын уснаас хангахаар шийдвэрлэсэн.

**10. Худаг өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал марк/:**

**Усны тоолуурын заалт 2024.09 сард .....м³ байна.**

**11. Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт> диаметр/:** Тодорхойлоогүй.

**12. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин:** Усан сан байгуулж, усыг тунгаан шүүх шүүлтүүр хийснээр усны 80%-ийг эргүүлж үйлдвэрлэлд ашиглаж байгаа. Олборлох үйлдвэрийн ажилчдын ахуйн бохир шингэнийг ариутгалын бодисоор батлагдсан аргачлалын дагуу ариутган энгийн хийц бүхий нүхэнд хаяна.

**13. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:** Уурхайн эдэлбэр газрыг сайтар цэвэрлэж хог хаягдлыг тогтоосон төвлөрсөн хогийн цэгт хүргэн зайлуулж ажиллах.

**14. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцоход:**

Төслийн усны хэрэгцээг Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын Сайдын 2015 оны А/301 дугаар тушаалаар батлагдсан нормын дагуу төслийн хүчин чадлаар тооцож үзэхэд:

Ажилчдын унд ахуйн хэрэгцээнд 19 хүн\*100л\*210хоног=399 м³/жил /унд ахуйд хэрэглэсэн усыг “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтад заасны дагуу төлбөрөөс чөлөөлнө/  
Зам талбайн тоосжилт дарах 2310м\*2л\*48хоног=221,76м³/жил



Мод усалгаа  $1000 \times 35 \times 40 \text{хон} = 1400 \text{м}^3$   
Нийт  $399 \text{м}^3 + 221,76 \text{м}^3 + 1400 \text{м}^3 = 2020,76 \text{м}^3$  ус шаардлагатай.

**15. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:**  
“Боржгоны тал” ХХК-ийн 2024 онд ашиглах газрын доорх усны төлбөрийн хэмжээг /хэмжих хэрэгслийн заалтаар тооцон/ Усны экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Туул голын сав газарт /БОНХЯамны сав газрын удирдлагын хэлтсийн лавлагаа/ тогтоосон суурь үнэлгээ, Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, 2013 оны 326-р тогтоолын 1-р хавсралтат, 2022 оны тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 416 дугаар тогтоолд заасан төлбөрийн хувь хэмжээг ашиглан тооцож, “Төсвийн тухай” хуулийн 23.6.5, 23.8.9-д заасны дагуу аймаг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх нь зүйтэй.  
Зам, талбайн тоосжилт дарахад газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:  
 $1 \text{м}^3 \text{ газрын доорх усны төлбөр } 9440 \text{төг/м}^3 \times 0,1 \times 0,20\% = 188,8 \text{төг/м}^3$   
 $9440 \text{төг/м}^3$ : Засгийн газрын 2011 оны 302-р тогтоолд заасан Туул голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэ  
0.1: Засгийн газрын 327-р тогтоолын авто замын зориулалтаар газрын доорх ус ашиглахад тооцох итгэлцүүр  
10%: Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 1-р хавсралтын 4-д заасан авто замын зориулалтаар газрын доорх усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ  
 $188,8 \text{төг} \times 10\% = 18,88 \text{төг}$   
 $188,8 \text{төг} + 18,88 \text{төг} = 207,68 \text{төг}$   
(Төв аймгийн Татварын хэлтсийн “Төв аймаг төрийн сан банк” дахь 100140000944 тоот данс)

**16. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар:** Уурхайн технологийн усны хэрэгцээг хангахдаа аль болох хэмнэлттэй технологи ашиглах, технологид усыг эргүүлэн ашиглах аргаа үргэлжлүүлэн ашиглах

**17. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:**

- “Усны тухай” хуулийн 28.6, 28.11-д заасны дагуу ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн Алтанбулаг сумын Засаг даргаас ус ашиглах зөвшөөрлийн эрхийг сунгуулах, ус ашиглах гэрээ байгуулж, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт бүртгүүлэх.
- “Усны тухай” хуулийн 30 дугаар зүйлийн дагуу ус ашиглагчдад тавигдах шаардлагыг хэрэгжүүлэн ажиллах
- Монгол улсын Засгийн газрын 2018.12.26-ны өдрийн 391-р тогтоолоор батлагдсан “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам”-ын дагуу илүү ашигласан усны хэмжээг хувь тооцон, шатлан өсгөхийг анхааруулж байна.
- Усны тоолуурт сумын БОХУ/Байцаагчаар хяналтын лац тавиулж, заалтыг тогтмол аван, тэмдэглэл хөтлөх, ус хэмнэлттэй ашиглах технологи нэвтрүүлэх, экологийн тэнцлийг хангахад шаардагдах хэмжээний нөөцийг байгальд заавал үлдээх, бохир ус цэвэрлэх технологийн горимыг мөрдөн ажиллах.
- Байгууллагын жил бүрийн Бизнес төлөвлөгөөнд үндэслэн усны хэрэглээг урьдчилан тооцуулж ус ашиглах дүгнэлтийг үйл ажиллагаа эхлэхээс нэг сараас доошгүй хугацааны өмнө гаргуулж, бодит хэрэглээг үнэн зөв тусгасан ус ашиглалтын тайланг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлэх.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН МЭРГЭЖИЛТЭН

Ж.ОЮУННАРАН

**“Бугат” элс хайрганы ордын 2024 оны Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

---

2024 онд олборлолт явуулсан талбайн солбицол: (WGS-84,UTM тусгагд)

Д.д	X	У	B	L
1	5289464.04	619637.61	47 44 50.80	106 35 45.82
2	5289463.15	619651.05	47 44 50.76	106 35 46.47
3	5289442.25	619657.37	47 44 50.08	106 35 46.75
4	5289444.10	619685.24	47 44 50.12	106 35 48.09
5	5289410.14	619706.15	47 44 49.01	106 35 49.06
6	5289407.44	619650.25	47 44 48.96	106 35 46.37



